# БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/108/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2026 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас: 70342716 Цахим хаяг: battsogtd@audit.gov.mn<br><br>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>“Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит” ХХК-ийн захирал: С.Оргил<br>Утас: 99197346 Цахим хаяг: info@shinjlenmagadlakhui-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ....... 3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 5-11
3. Аудитын тайлан ....... 11-12
4. Аудитын илрүүлэлт ....... 13
5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ....... **14**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 105

танай ______ ны № ______ т

БУЛГАН СУМЫН 6 ДУГААР
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.НАНСАЛМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн 6 дугаар хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын 6 дугаар хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Булган аймгийн Булган сумын 6 дугаар цэцэрлэг нь 2025 онд 132 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж үүнээс 132 хүүхэд үндсэн цэцэрлэгт хамрагдаж гүйцэтгэлээр санхүүжсэн.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Булган сумын 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Б.Нансалмаа нь Булган аймгийн боловсролын газрын даргатай 2025 онд байгуулсан гүйцэтгэлгээний төлөвлөгөө нь 5 зорилт, 43 арга хэмжээний хүрээнд 90.67 хувиар үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

6326050210

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **4** | **56,097,599.39** | **18,199,533.72** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | 56,097,599.39 | 18,199,533.72 |
| 3121 | Төгрөг | | 56,097,599.39 | 18,199,533.72 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 56,097,599.39 | 18,199,533.72 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | **54,872,817.40** | **65,375,733.40** |
| 351 | Түүхий эд материал | | 112,100.00 | - |
| 3513 | Эм боох материал | | 112,100.00 | - |
| 354 | Хангамжийн материал | | 54,760,717.40 | 65,375,733.40 |
| 3541 | Бичиг хэргийн материал | | 417,000.00 | 740,000.00 |
| 3542 | Аж ахуйн материал | | 22,279,438.00 | 18,002,100.00 |
| 3546 | Хүнсний материал | | 15,476,380.00 | 7,763,480.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | | 16,587,899.40 | 38,870,153.40 |
| **I** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **110,970,416.79** | **83,575,267.12** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | **411,709,870.42** | **408,863,895.68** |
| 392 | Биет хөрөнгө | | 370,124,453.49 | 367,303,478.71 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 387,901,207.26 | 386,473,389.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (73,076,202.36) | (83,746,900.20) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 40,152,314.00 | 64,019,501.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (8,409,406.66) | (19,392,704.34) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 25,742,551.00 | 26,589,183.34 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (15,715,961.81) | (17,053,682.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 14,807,014.40 | 14,807,014.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (3,966,817.34) | (7,131,577.82) |
| 39217 | Ном | | 2,689,755.00 | 2,739,255.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | **41,585,416.93** | **41,560,416.97** |
| 39301 | Програм хангамж | | 1,600,000.00 | 250,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,514,583.07) | (189,583.03) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 41,500,000.00 | 41,500,000.00 |
| **II** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **411,709,870.42** | **408,863,895.68** |
| **III** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | - | **522,680,287.21** | **492,439,162.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **522,680,287.21** | **492,439,162.80** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 151,245,003.07 | 151,245,003.07 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | | (10,209,075.20) | (40,450,199.61) |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | | (10,209,075.20) | (10,209,075.20) |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | | (30,241,124.41) |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 381,644,359.34 | 381,644,359.34 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 522,680,287.21 | 492,439,162.80 |
| **VI** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | - | **522,680,287.21** | **492,439,162.80** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **824,245,000.00** | **1,072,241,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | **616,639,900.00** | **741,570,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 616,639,900.00 | 741,570,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | **207,605,100.00** | **330,671,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 207,605,100.00 | 330,671,000.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **38,110,925.00** | **60,075,039.34** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 38,110,925.00 | 60,075,039.34 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | - | 50,173,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | - | 50,173,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 32,170,725.00 | 2,143,539.34 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 5,940,200.00 | 7,758,500.00 |
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **862,355,925.00** | **1,132,316,139.34** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **879,018,881.95** | **1,162,557,262.63** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 877,760,966.01 | 1,158,914,636.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **505,166,754.54** | **646,452,881.10** |
| 210101 | Үндсэн цалин | | 350,363,160.54 | 413,782,519.78 |
| 210102 | Нэмэгдэл | | 148,898,594.00 | 183,904,455.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | - | 21,982,406.08 |
| 210104 | Урамшуулал | | 5,905,000.00 | 26,783,500.06 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **62,443,553.11** | **73,076,534.57** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 42,485,807.71 | 49,884,888.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 5,059,745.78 | 6,188,066.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 2,594,201.52 | 3,120,536.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 2,460,757.54 | 2,706,684.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 9,843,040.56 | 11,176,357.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **203,547,184.06** | **322,229,773.49** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 6,564,957.41 | 9,761,793.49 |
| 210302 | Түлш, халаалт | | 106,603,182.65 | 183,142,080.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 6,708,430.00 | 6,796,900.00 |
| 210304 | Байрны түрээс | | 83,670,614.00 | 122,529,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **3,028,844.40** | **7,922,384.00** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 3,028,844.40 | 7,922,384.00 |
| 2105 | Нормативт зардал | | 47,212,800.00 | 48,142,150.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 47,212,800.00 | 48,142,150.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **2,700,000.00** | **2,965,500.00** |
| 210604 | Урсгал засвар | | 2,700,000.00 | 2,965,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **1,233,200.00** | **2,407,500.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,233,200.00 | 2,407,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **52,428,629.90** | **55,717,912.96** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 17,310,100.00 | 15,850,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 5,039,200.00 | 4,278,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 30,079,329.90 | 35,589,012.96 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 1,257,915.94 | 3,642,626.51 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 1,257,915.94 | 3,642,626.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,257,915.94 | 3,642,626.51 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3** | **879,018,881.95** | **1,162,557,262.63** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **(16,662,956.95)** | **(30,241,123.29)** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 0.36 | 1.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 0.36 | 1.12 |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | **(0.36)** | **(1.12)** |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | - | **(16,662,957.31)** | **(30,241,124.41)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **824,245,000.00** | **1,122,414,100.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 50,173,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 50,173,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 50,173,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 50,173,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **824,245,000.00** | **1,072,241,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **616,639,900.00** | **741,570,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 616,639,900.00 | 741,570,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **207,605,100.00** | **330,671,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 207,605,100.00 | 330,671,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **848,491,837.65** | **1,129,712,665.67** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 848,491,837.65 | 1,129,712,665.67 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 847,233,921.71 | 1,126,070,039.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **505,166,754.54** | **646,452,881.10** |
| 210101 | Үндсэн цалин | 350,363,160.54 | 413,782,519.78 |
| 210102 | Нэмэгдэл | 148,898,594.00 | 183,904,455.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 21,982,406.08 |
| 210104 | Урамшуулал | 5,905,000.00 | 26,783,500.06 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **62,443,553.11** | **73,076,534.57** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,485,807.71 | 49,884,888.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,059,745.78 | 6,188,066.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,594,201.52 | 3,120,536.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,460,757.54 | 2,706,684.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,843,040.56 | 11,176,357.98 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **203,547,184.06** | **322,229,773.49** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,564,957.41 | 9,761,793.49 |
| 210302 | Түлш, халаалт | 106,603,182.65 | 183,142,080.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,708,430.00 | 6,796,900.00 |
| 210304 | Байрны түрээс | 83,670,614.00 | 122,529,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **53,727,830.00** | **40,429,250.00** |
| 210502 | Хоол, хүнс | 53,727,830.00 | 40,429,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,800,000.00** | **4,798,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,800,000.00 | 4,798,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,883,200.00** | **2,802,500.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,883,200.00 | 2,802,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **17,665,400.00** | **36,280,500.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,626,200.00 | 31,155,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,039,200.00 | 5,125,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,257,915.94 | 3,642,626.51 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,257,915.94 | 3,642,626.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,257,915.94 | 3,642,626.51 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(24,246,837.65)** | **(7,298,565.67)** |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 2,869,700.00 | 30,599,500.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 2,869,700.00 | 30,599,500.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,869,700.00 | 30,599,500.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (2,869,700.00) | (30,599,500.00) |

| | | | |
|---|---|---|---|
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (27,116,537.65) | (37,898,065.67) |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **56,097,599.39** | **56,097,599.39** |
| **31** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **18,199,533.72** | **18,199,533.72** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **151,245,003.07** | **381,644,359.34** | **6,453,882.11** | **539,343,244.52** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Тайлант үеийн үр дүн | - | - | (16,662,957.31) | (16,662,957.31) |
| **4** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **151,245,003.07** | **381,644,359.34** | **(10,209,075.20)** | **522,680,287.21** |
| 5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 6 | Тайлант үеийн үр дүн | - | - | (30,241,124.41) | (30,241,124.41) |
| **7** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **151,245,003.07** | **381,644,359.34** | **(40,450,199.61)** | **492,439,162.80** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* /Төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| **ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО** | **1,072,241,100.00** | **1,072,241,100.00** | **-** | **100** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **741,570,100.00** | **741,570,100.00** | **-** | **100** |
| Улсын төсвөөс санхүүжих | 741,570,100.00 | 741,570,100.00 | - | 100 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **330,671,000.00** | **330,671,000.00** | **-** | **100** |
| Орон нутгийн төсвөөс | 330,671,000.00 | 330,671,000.00 | - | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 50,173,000.00 | 50,173,000.00 | - | 100 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,173,000.00 | 50,173,000.00 | - | 100 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,122,414,100.00 | 1,122,414,100.00 | - | 100 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,165,839,900.00** | **1,129,712,665.67** | **36,127,234.33** | **96.9** |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,165,839,900.00 | 1,126,070,039.16 | 39,769,860.84 | 96.59 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **641,230,400.00** | **646,452,881.10** | **(5,222,481.10)** | **100.81** |
| Үндсэн цалин | 436,209,000.00 | 413,782,519.78 | 22,426,480.22 | 94.86 |
| Нэмэгдэл | 194,905,100.00 | 183,904,455.18 | 11,000,644.82 | 94.36 |
| Унаа хоолны хөнгөлөлт | | 21,982,406.08 | (21,982,406.08) | |
| Урамшуулал | 10,116,300.00 | 26,783,500.06 | (16,667,200.06) | 264.76 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **79,682,500.00** | **73,076,534.57** | **6,605,965.43** | **91.71** |
| Тэтгэврийн даатгал | 54,041,200.00 | 49,884,888.59 | 4,156,311.41 | 92.31 |
| Тэтгэмжийн даатгал | 6,410,300.00 | 6,188,066.09 | 222,233.91 | 96.53 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,205,200.00 | 3,120,536.93 | 84,663.07 | 97.36 |
| Ажилгүйдлийн даатгал | 3,205,200.00 | 2,706,684.98 | 498,515.02 | 84.45 |
| Эрүүл мэндийн даатгал | 12,820,600.00 | 11,176,357.98 | 1,644,242.02 | 87.17 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **325,871,000.00** | **322,229,773.49** | **3,641,226.51** | **98.88** |
| Гэрэл, цахилгаан | 10,204,000.00 | 9,761,793.49 | 442,206.51 | 95.67 |
| Түлш, халаалт | 183,138,000.00 | 183,142,080.00 | (4,080.00) | 100 |
| Цэвэр, бохир ус | 10,000,000.00 | 6,796,900.00 | 3,203,100.00 | 67.97 |
| Байрны түрээс | 122,529,000.00 | 122,529,000.00 | | 100 |
| **Нормативт зардал** | **45,244,100.00** | **40,429,250.00** | **4,814,850.00** | **89.36** |
| Хоол, хүнс | 45,244,100.00 | 40,429,250.00 | 4,814,850.00 | 89.36 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,800,000.00** | **4,798,600.00** | **1,400.00** | **99.97** |
| Урсгал засвар | 4,800,000.00 | 4,798,600.00 | 1,400.00 | 99.97 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,802,600.00** | **2,802,500.00** | **100.00** | **100** |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,802,600.00 | 2,802,500.00 | 100.00 | 100 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **66,209,300.00** | **36,280,500.00** | **29,928,800.00** | **54.8** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 61,031,400.00 | 31,155,000.00 | 29,876,400.00 | 51.05 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,177,900.00 | 5,125,500.00 | 52,400.00 | 98.99 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 3,642,626.51 | (3,642,626.51) | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох | - | 3,642,626.51 | (3,642,626.51) | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,642,626.51 | (3,642,626.51) | |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 30,599,500.00 | (30,599,500.00) | |
| Дотоод эх үүсвэрээр | - | 30,599,500.00 | (30,599,500.00) | |
| Бусад хөрөнгө | - | 30,599,500.00 | (30,599,500.00) | |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **1,165,839,900.00** | **1,160,312,165.67** | **5,527,734.33** | **99.53** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **56,097,599.39** | **56,097,599.39** | **(56,097,599.39)** | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **18,199,533.72** | **18,199,533.72** | **(18,199,533.72)** | |

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Шинжлэн магадлахуй ЭЗШ Аудит ХХК-ийн аудитын баг гүйцэтгэж, үе шатны хяналтыг хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол нар хэрэгжүүлэв.

Булган аймгийн 6 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардал 848,245.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,727.37 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 9,542.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

*Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд* чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох, нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх, .хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох зэрэгтэй холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэр, орлого зарлага мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

#### 3.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 3.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг Фас системээр хийж гүйцэтгэсэн.

#### 3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 1,230.6 мянган  төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | Биелэлт |
|---|---|---|

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| Зөвлөмж | 2 | 1,230.6 | 2 | 1,230.6 | 100% |
| **Нийт дүн** | **2** | **1,230.6** | **2** | **1,230.6** | **100%** |

### 3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалт
2. Хоол хүнсний материалын худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэлд анхаарах нь зүйтэй.

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа илрээгүй болно.

Аудитаар 1 зөрчил[1] илэрч 1 зөвлөмж өгсөн.
Аудитаар илэрсэн асуудлаар зөрчил нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аудитаар дараах 2 зөвлөмж өгсөн болно.

#### 4.1.1. Санхүүгийн программын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:**

Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглаагүй, бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулж, анхан шатны баримтыг ихэнхийг гараар хөтөлсөн нь “ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -т 'тасралтгүй байх' гэсэн зарчим, 13.1' Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно' гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын орлого болон зарлагыг тухай бүрт нь программд бүртгэн бараа материалын зарцуулалтын тайланг үнэн зөв, цаг хугацаанд тайлагнах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн программыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглаагүй, бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн өдөр нэгтгэн нэг удаа программд шивж оруулж, анхан шатны баримтыг ихэнхийг гараар хөтөлсөн | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **1** | **0** | | | | | **1** | **0** | | | | |